



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/1067

Улаанбаатар хот

Нийслэлийн үнэт цаас гаргах  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дүгээр зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйл, Өрийн удирдлагын тухай хуулийн 28<sup>1</sup> дугаар зүйлийн 28<sup>1.1</sup> дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 282 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 55, 97 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн 2023 оны төсөвт тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор “Улаанбаатар бонд”-ын эхний үе шатанд 277,863,500,000.0 (хоёр зуун далан долоон тэрбум найман зуун жаран гурван сая таван зуун мянга) төгрөгийн үнэт цаасыг хавсралтад заасан нөхцөлийн дагуу гаргасугай.

2.“Улаанбаатар бонд”-ын эхний үе шатыг дотоодын зах зээлд гаргаж, арилжих нөхцөлийг 1 дүгээр, санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.“Улаанбаатар бонд”-ыг андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар дамжуулан хөрөнгө оруулагчдад санал болгон арилжаалж, хөрөнгө татан төвлөрүүлэх ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү)-т, үндсэн болон хүүгийн төлбөрийг нийслэлийн жил бүрийн төсөвт тусгах ажлыг зохион байгуулж, хуваарьт хугацаанд төлж барагдуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

4.“Улаанбаатар бонд”-ыг арилжаалах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдийг гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Б.Бямбасүрэн)-т, нээсэн эрхийг үндэслэн хуваарийн дагуу санхүүжүүлж, гүйцэтгэлийг тайлагнан ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т тус тус даалгасугай.

5.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэнд үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



1110204668

Нийслэлийн Засаг даргын 2023 оны  
09 дугаар сарын 17-ны өдрийн  
захирамжийн  
дүгээр хавсралт

“УЛААНБААТАР БОНД”-ЫН ЭХНИЙ ҮЕ ШАТАНД ДОТООДЫН  
ЗАХ ЗЭЭЛД ГАРГАЖ, АРИЛЖИХ НӨХЦӨЛ

Үнэт цаасны төрөл	Дунд хугацаат орон нутгийн бонд
Үнэт цаасны хугацаа	24 сар
Үнэт цаасны хүү	17.2%
Арилжаалах үнэт цаасны нэг бүрийн үнэ (төгрөг)	100,000.0
Арилжаалах үнэт цаасны тоо ширхэг	2,778,635
Хүү (купон) төлөх давтамж	Хагас жил тутам
Үндсэн төлбөр төлөх хугацаа	Хугацааны эцэст
Арилжааны хэлбэр	Тогтсон үнийн арга
Бондын хэлбэр	Тогтмол хүүтэй

Нийслэлийн Засаг даргын 2023 оны  
09 сарын 13-ны өдрийн  
захиралтын захирамжийн  
2 дугаар хавсралт

“УЛААНБААТАР БОНД”-ЫН ЭХНИЙ ҮЕ ШТАНД ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН  
ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Санхүүжих дүн
1	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор (Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, 100 дугаар цэцэрлэг)	1,500,000,000.0
2	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 200 ор (Сүхбаатар дүүрэг, 10 дугаар хороо, 234 дүгээр цэцэрлэг)	2,655,432,181.0
3	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор (Баянзүрх дүүрэг, 18 дугаар хороо, 129 дүгээр цэцэрлэг)	1,000,000,000.0
4	Цэцэрлэгийн барилга, 150 ор (Баянгол дүүрэг, 11 дүгээр хороо, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн цэцэрлэг)	1,700,000,000.0
5	Цэцэрлэгийн байр, 100 ор (Хан-уул дүүрэг, 3 дугаар хороо)	608,400,000.0
6	Орон сууцны 1 давхар, 75 ор /Баянзүрх дүүрэг, 5 дугаар хороо/	165,500,000.0
7	Бие даасан барилга, 50 ор (Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хороо)	270,000,000.0
8	Орон сууцны 1 давхар, 150 ор /Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо/	288,000,000.0
9	152 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Налайх дүүрэг, 1 дүгээр хороо)	574,604,222.0
10	6 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Баянзүрх дүүрэг, 28 дугаар хороо)	551,256,457.0
11	201 дүгээр цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Баянзүрх дүүрэг, 4 дүгээр хороо)	494,473,364.0
12	202 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Баянзүрх дүүрэг, 21 дүгээр хороо)	557,771,652.0
13	297 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Баянзүрх дүүрэг, 17 дугаар хороо)	484,296,492.0
14	165 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Хан-Уул дүүрэг, 14 дүгээр хороо)	423,267,288.0
15	12 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо)	542,981,346.0
16	164 дүгээр цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Баянгол дүүрэг, 4 дүгээр хороо)	411,184,705.0
17	271 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Сонгинохайрхан дүүрэг, 33 дугаар хороо)	423,267,288.0
18	188 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Сонгинохайрхан дүүрэг, 33 дугаар хороо)	595,308,661.0
19	111 дүгээр цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Сонгинохайрхан дүүрэг, 1 дүгээр хороо)	551,491,627.0
20	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо/	1,200,407,316.0

21	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо/	2,929,048,910.0
22	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12 дугаар хороо/	3,467,900,000.0
23	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 19 дүгээр хороо/	3,886,700,000.0
24	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 8 дугаар хороо/	932,524,289.0
25	Цэцэрлэгийн барилга худалдан авах, 280 ор /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 36 дугаар хороо/	2,387,000,000.0
26	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор (Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо, Нью Хабитат хороолол)	2,500,000,000.0
27	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор (Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо, Био комбинат)	2,500,000,000.0
28	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор (Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо)	3,000,000,000.0
29	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор (Хан-Уул дүүрэг, 14 дүгээр хороо)	2,500,000,000.0
30	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор (Хан-Уул дүүрэг, 9 дүгээр хороо)	2,500,000,000.0
31	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор (Сонгинохайрхан дүүрэг, 8 дугаар хороо)	1,000,000,000.0
32	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор (Сонгинохайрхан дүүрэг, 33 дугаар хороо, Тахилт)	2,500,000,000.0
33	Голомт цогцолбор сургуулийн барилга буулгаж барих, 960 суудал /Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 2 дугаар хороо/	2,192,110,159.0
34	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 8 дугаар хороо/	6,000,000,000.0
35	Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 4 дүгээр хороо/	3,600,000,000.0
36	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо/	5,907,117,243.0
37	Нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, инженерийн дэд бүтцийн хүртээмж, авто зам, замын байгууламжийн төсөл, арга хэмжээ	14,457,300,000.00
38	Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан хангамжийн 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажил (Улаанбаатар хот, Налайх дүүрэг)	13,208,800,000.00
39	Багануур үйлдвэрлэл технологийн паркийн ерөнхий цахилгаан хангамжийн ажил (Улаанбаатар хот, Багануур дүүрэг)	1,100,000,000.00
40	Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор хагас коксон шахмал түлш үйлдвэрлэж, нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд нийлүүлэх ажлын хүрээнд шахмал түлшний үндсэн түүхий эд болох хагас кокс болон асаагч худалдан авах ажил	31,914,000,000.0
41	"Сэлбэ сэргэлт" төслийн эхний ээлжийн бүтээн байгуулалтын ажил (Улаанбаатар хот)	150,000,000,000.0
42	Үнэт цаас гаргах зардал (Улаанбаатар хот)	4,383,296,712.5
	НИЙТ ДҮН	277,863,439,912.5